

**“ГЕОДЕЗИ, УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН  
2024 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 01 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

“Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ нь Улаанбаатар хотын иргэдийн тав тухтай байдлыг хангах эрүүл аюулгүй орчинд амьдроулах үүднээс үерийн хамгаалалтын далан суваг, борооны үс зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулах болон үер усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

**НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
БҮРЭН ХАНГАН АЖИЛЛАЖ, ХАРИУЛАГА, САХИЛГА БАТЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ.  
(НИЙСЛЭЛИЙН 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ, 2024 ОНЫ ХӨГЖЛИЙН  
ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ)-ЫН ХҮРЭЭНД:**

“Сөүл” эмнэлэгтэй хамтран ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгт 2024 оны 02 сарын 01-ээс 02 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулж байгууллагын 90 ажилтан хамрагдсанаас лабораторийн шинжилгээнд 82, багажийн шинжилгээ болон эмчийн үзлэгт 75 албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг оншилгоонд хамруулан ажилласан. Үүнд:

- Шээсний ерөнхий шинжилгээ
- Биохимийн шинжилгээ
- Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
- Элэгний ВС вирус тодорхойлох
- Сахар
- Холестрин
- Элэгний хавдрын маркер
- Дотор /зүрхний цахилгаан бичлэг, хodoодний хеликобактер/
- ЭХО оношилгоо
- Зүрхний бичлэг
- Рентген /уушигний/

зэрэг нийт 11 оношилгоонд хамруулж шаардлагатай эмчилгээ өгч, зөвлөгөө мэдээллээр хangan ажилласан.



Анхан шатны тусламж үзүүлэх, хэт халуун болон хэт хүйтэн өдрүүдэд ажилчдын даралт хэмжих, халуун үзэх эм бэлдмэлээр хangan шаардлагатай тохиолдолд жоргуй олгодог эмээр хangan ажилласан.



Мөн Чимэг-Оюу эмэгтэйчүүдийн эмнэлэгт нийт эмэгтэй ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан.

2024.10.08, 10-нд 2 өдөр “Эрдэс амин дэм дутагдлын оношилгооны аппарат”-нд нийт ажилтан, албан хаагчдыг хамруулан ажилласан.

### Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр хийгдсэн ажил:

2024 оны 06 сарын 05 ны 09 сарын 05 ны өдрүүдэд халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 удаа /САНХИМИ ХХК/ хамтран халдвартгүйжүүлэлт хийлгэн ажиллаа.



2024 онд нийт 21 хүн ажилд шинээр орсон ба орсон цаг хугацаа бурд нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилсан зааварчилгааг өгөн, хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгсэлээр ханганд ажиллаа.



Ажлын талбай дээр ажиллаж буй ажилтан албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг шалгах зорилгоор нийт 20 удаагийн үзлэг шалгалт хийн ажиллав.



Нийт байгууллагын хэмжээнд галын хорыг шалгалт үзлэг хийн дахин нийт 24 хорыг цэнэглүүлэн ажилсан.



Монгол улсын засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам” 340-р тогтоолоор баталсан “Гамшигийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор улс орон даяар зохион байгуулсан дадлага сургуулилтад нийт албан хаагчдыг хамрууллаа.

1. Ажлын талбайд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс хамгаалалтын туз, аюулгүйн гэрлэн тохио, түмбэ байрлуулан ажилласан.



2. Гамшигийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс улс орон даяар зарлан мэдээллийн дохиог 3 удаа дамжуулнаар албан хаагчид нэгдсэн зохион байгуулалтад орж:

1. Эхний дохио дуугарахад “Сүү, Нуугд, Хүлээ” гэсэн дүрмийг баримталж аль болох шил, цонхноос хол, бат бех ширээн доогуур орж бие болон толгойгоо халхлан аюулгүй байдлаа хангаж түр хүлээх,
2. Хоёр дахь дохио дуугарахад хамт олноороо байгаа бол толгойгоо халхлан яарч сандралгүй нэгийн цуваанд орж баруун гар талаа барьж, “гүйхгүй, эргэж буцахгүй, нэгнээ түлхэхгүй” гэсэн дүрмээ баримталж, байгаа газраасаа гарч, аюулгүй талбайд цугларсан..
3. Гурав дахь дохио дуугарахад байгууллагын холбогдох албан тушаалтанд бүртгүүлж, гэр бүлийн гишүүд, хамт олны мэдээллийг үнэн зөв тодорхой өгч дадлага сургуулалтыг хийж гүйцэтгэсэн.



#### **Хүний хөгжлийн зорилтот түвшинг бүрэн хангах ажлын хүрээнд хийгдсэн ажил:**

Тус байгууллагын спорт хороо байгууллагын Ажилчдын Үйлдвэрчний эвлэлтэй хамтран Геодези, усны барилга байгууламжийн газрын нийт ажилтан, албан хаагчдын эрүүл, чийрэг бие бялдарыг хөгжүүлэх, эрч хүч, нэгдмэл хамт олон болгох зорилготой "СПОРТ

“ӨДӨРЛӨГ 2024” спорт өдөрлөгийг “САГСАН БӨМБӨГ, ГАР БӨМБӨГ, ШИРЭЭНИЙ ТЕННИС” гэсэн 3 төрлөөр зохион байгуулж шилдэг баг, тамирчдыг шалгаруулсан.



Нийт ажилтан албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор спорт заалтай 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл гэрээ байгуулж Мягмар гариг бүр тогтмол заал авч дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн.

Мөн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн нэрэмжит харьяа байгууллагуудын дунд зохион байгуулсан 5 төрлийн спортын арга хэмжээнд Сагсан бөмбөг, Гар бөмбөг, Дартс, Ширээний тенис, Шатар зэрэгт байгууллагын ажилчдыг бүрэн хамруулсан.



## Хүний нөөцийн бодлогын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

### 1. Сургалт хөгжлийн чиглэлээр:

Байгууллагын 2024 оны “Сургалтын төлөвлөгөө”-д оруулах сургалтын хэрэгцээ, шаардлагын судалгааг 7 хэлтэс, албанаас авч нэгтгэж судалгаа хийж 9 нэр төрлийн сургалтын төлөвлөгөөгээ боловсруулсан.

Тухайн жилд цахимаар болон танхимиын хосолсон нийт 14-н удаагийн сургалтын ўйл ажиллагаа зохион байгуулагдсан. Тухайн сургалтуудад удирдлагууд болон ажилтан албан хаагчид идэвхтэй чиглэл чиглэлээр хамрагдсан.

2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Худалдан авах ажиллагааны АЗ-н сертификаттай сургалтад нийт 4 ажилтан албан хаагчийг хамруулж 4 ажилтан албан хаагч тэнцсэн.

### 2. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зорилгоор:

2024 онд ажилтнуудын нийгмийн баталгаа, тогтвортой ажлын байр бий болгох, албан хаагчдыг идэвхижүүлэх ажлын хүрээнд 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийт ажилчдын цалинг 30% нэмэгдэж олгогдохоор батлуулсан. Мөн тус газрын Удирдах зөвлөлийн 2024.07.01-ний өдрийн 07-р тогтоолоор ажилчдын цалинг 2 сая-3,5 сая болтол албан тушаалын шатлалтайгаар нэмэгдүүлсэн.

№	Он сар	Нийт цалин олгосон	Үр чадварын нэмэгдэл	Бусад нэмэгдэл	Илүү цаг
1	2024 оны 01-р сар	105	80	12	99
2	2024 оны 02-р сар	106	66	6	61
3	2024 оны 03-р сар	103	72	6	69
4	2024 оны 04-р сар	106	80	6	64
5	2024 оны 05-р сар	107	75	6	72
6	2024 оны 06-р сар	109	77	6	80
7	2024 оны 07-р сар	103	74	6	
8	2024 оны 08-р сар	121	81	6	3
9	2024 оны 09-р сар	120	78	6	2
10	2024 оны 10-р сар	119	82	4	5
11	2024 оны 11-р сар	118	81	5	76
12	2024 оны 12-р сар	120	89	106	69

2. 2024 оны “Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө”-д тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, нийгмийн баталгааг хангах ажлыг холбогдох байгууллага, нэгж, ажилтнуудтай хамтран хэрэгжүүлж байна.

3. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр (2021-2024)-т тусгагдсан нийгмийн асуудлыг шийдвэрлэх, туслалцаа үзүүлэх тэтгэмж олгох ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Шинээр төрсөн хүүхдийн тэтгэмж-7
2. Шинэ байранд орсон-5
3. Буцалтгүй тусламж-3
4. Цалинтай чөлөө-1
5. Өндөр настны тэтгэмж-2

4."Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийн хүрээнд биелэлтийг үзүүлэлт тус бүрээр гаргаж, улирал бүр үр дүнг тооцож ажилласан. Эхний хагас жилд хүний нөөцийн бурдуулэлтэд онцгой анхаарч хэлтэс, албадтай үр дүнтэй хамтран ажилласан бөгөөд нийт 35 ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан хувийн хэргийн баяжилт хөдөлгөөнийг хийж мэдээлэл судалгаа хийсэн.

5.Ажилтнуудыг ур чадварын шалгуураар ажилд дэвшиүүлэх, цогц арга хэмжээг авч ажиллах ажлын хүрээнд 1 ажилтныг Диспетчерийн албан тушаалаас Архивын ажилтан, 1 ажилтныг Машинист албан тушаалаас Техникч, Автомеханикч албан тушаалаас Хүнд даацийн ачааны машины жолбооч, 2 засварчинг насос станцын машинистаар, 1 автын засварчинг экскаваторчин, 1 ажилтан Үндсэн хөрөнгийн няраваас Эрүүл ахуйчийн албан тушаалд дэвшиүүлэн томилж хүний нөөцийг бурдуулсэн.

6.Нидерландын Вант Улсын Гадаад хэргийн яам, Дэд бүтэц усны менежментийн яамнаас дэмжлэг үзүүлдэг Голландын Аж ахуйн нэгжийн агентлагийн (RVO), Гамшигийн эрсдэлийг бууруулах (DRRS) хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж, дараах 3 чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.

### ҮЕРИЙН ХАМГААЛАЛТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗАСВАР АРЧЛАЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

#### **НЭГ. ҮЕРИЙН ХАМГААЛАЛТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХАЛИА ДОШИН БАГАСГАХ АЖИЛ:**

Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн халиа дошин арилгах ажлыг Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын далан сувгийн бригад нь:

1. СБД-ийн 14-р хороо Чингэлтэйн суваг,
2. ЧД-ийн 10-р хороо Дэнжийн 1000-ын 1-р суваг
3. ЧД-ийн 11,12-р хороо Дэнжийн 1000 3-р суваг,
4. СХД-ийн 19, 27-р хороо Толгойтын суваг
5. СБД-ийн 9-р хороо Ногоон нуурын үсрэс хамгаалах байгууламжид үүссэн халиа дошин багасгах ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн хооронд 0,65 м3 шанагат экскаватор 2, хунд даацын /6-20тн/ ачааны машин 3-5, үйлчилгээний машин 3, бобкат 1, кран 1, ковш 1 бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Халиа дошин багасгах ажлын хүрээнд нийт **10306 м3** мөсийг ухаж суваг татах, суваг сэргээх овоолох, ажлыг механизмаар, **1773 м3** мөсийг ухах, суваг татах, суваг сэргээх ажлыг гар ажиллагаагаар, автозамын ус гаргуур, гүүрэн гарцны доорхи гаргалгаа хэсгийн **1214,4 м3** мөсийг ухах **1710 м3** мөс зөөж тээвэрлэх, **1462 тн** шороон тээвэрлэн шороон хаалт хийх, халиа үүссэн гүүрэн гарцны хэсэгт **60 м3** ус соруулах, ус гаргуур, зам талбайн мөстсөн хэсэгт **1.65 тн** хайлуулах бодис хийх зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэн аюулгүй байдлыг ханганд ажилласан.


**Халиа дошин багасгах ажлын хүрээнд:** нийт 13293,4м3 мөсийг ухах, суваг татах, суваг сэргээх овоолох, ажлыг хийж гүйцэтгэж, 1462тн шороон хаалт хийж, 1710м3 мөс зөөж тээвэрлэх, 60м3 ус соруулах, зам талбайн мөстсөн хэсэгт 1.65тн хайлуулах давс хийх зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэн аюулгүй байдлыг ханганд ажилласан.

Үүчд:

- Механизмаар: 10306 м3
- Гар ажиллагаагаар: 1773 м3
- Гүүрэн гарцны доор 1214,4 м3 ажилласан.




ЧД-ийн 18-р хороонд байрлалтай Чингэлтэйн сувагт иргэний өгсөн дуудлагын дагуу хальж урссан хэсэгт 2-рейс 40 тн шороо буулган механизмаар шороон хаалт хийж айл өрх рүү ус орохос сэргийлэн аюулгүй байдлыг ханган ажилласан.



БЗД-ийн 5-р хороо Зүүн уулын сувгийн далд гаргалгаа хэсэгт 2250м<sup>3</sup> ус соруулах, гаргалгаанаас гарсан илуүдэл 35 м<sup>3</sup> месийг зөөж тээвэрлэсэн.



БЗД 11-р хороо Хонхор шар усны үерийн улмаас тогтсон хэсэгт механизмаар 250м суваг татах, усыг помпоор 4-н цаг 1200м<sup>3</sup> ус соруулан аюулгүй байдлыг ханган ажилласан.



СХД 6-р хороо Намгийн сувгийн далд бөглөрсөн хэсэгт 36 м<sup>3</sup> ус соруулах, 54 тн лаг хагшаас зөөж тээвэрлэх ажлыг тус тус хийж гүйцэтгэн аюулгүй байдлыг ханган ажилласан.



БГД-ийн 12-р хороонд байрлалтай 28-р сургуулийн урд талын ТТ-3 тунгаагуурт 40м/урт үерийн хамгаалалтын хайс хашлага угсарч суурилуулан, шонгийн суурийг гар ажиллагаагаар бетондож, иргэд, хүүхдүүд унаж бэртэхээс сэргийлэн аюулгүй байдлыг ханган ажилласан.



**ХОЁР. ҮЕРИЙН ХАМГААЛАЛТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НИЙТ 46 БАЙРШИЛД**  
**ЛАГ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭН 46668 М3**  
**ЛАГ ХАГШААС ЗӨӨЖ ТЭЭВЭРЛЭСЭН**

БЗД-ийн 29-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Сэлбэ голын далангийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хооронд Өөрөө буулгагч хүнд даацын ачааны машинаар 239 рейсээр 3767 м3 лаг хагшаасыг Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажиллалаа.



ХУД 8-р хороо Сонсголонгийн сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэн 9 рейсээр 104 м3 лаг хагшаасыг Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



ХУД 10-р хороо Нисэхийн сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэн 23 рейсээр 331,5 м3 лаг хагшаасыг Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



ЧД 13,14-р хороо Хайлаастын сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэн 167 рейсээр 2771,7 м3 лаг хагшаасыг Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.




ХУД 11,22-р хороо Зайсангийн сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэн 40 рейсээр 522 м3 лаг хагшаасыг Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



СБД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Сэлбийн туслах сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хооронд Өөрөө буулгагч хүнд даацын ачааны машинаар 19 рейсээр 297,3 м<sup>3</sup> лаг хагшаасыг Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



БГД 20-р хороо, ХУД 03-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Баруун уулын сувгийн төгсгөл хэсгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хооронд Өөрөө буулгагч хүнд даацын ачааны машинаар 121 рейсээр 2044 м<sup>3</sup> лаг хагшаасыг Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Биокомбинатын сувгийн хэсгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хооронд өөрөө буулгагч хүнд даацын ачааны машинаар 33 рейсээр 489,8 м<sup>3</sup> лаг хагшаасыг Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



ЧД 10-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Дэнжийн мянгын 1 дүгээр сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хооронд өөрөө буулгагч хүнд даацын ачааны машинаар 47 рейсээр 801,8 м<sup>3</sup> лаг хагшаасыг Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



ЧД 11,12-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Дэнжийн мянгын 3 дугаар сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 10-

ны өдрийн хооронд өөрөө буулгагч хүнд даацын ачааны машинаар 52 рейсээр 845,6 м3 лаг хагшаасыг Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



БГД-ийн 23-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Телевизийн тунгаагуурын лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хооронд 123 рейсээр 1900 м3 лаг хагшаасыг Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



БЗД-ийн 27,29-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Ганц худгийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд 103 рейсээр 1562 м3 лаг хагшаасыг Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.




СБД-ийн 15,16-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Бэлхийн далангийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд 207 рейсээр 3857 м3 лаг хагшаасыг Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



Биокомбинатын сувгийн хэсгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хооронд 100 рейсээр 1986 м3 лаг хагшаасыг Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.




Чингэлтэй дүүргийн 09 дүгээр хороо тасганы зүүн суваг, Чингэлтэй дүүрэг 05 дугаар хороо гэсэр сүмийн баруун сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 53 рейсээр 674,3 м<sup>3</sup> лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.




Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо толгойтын суваг шинэ замаас үйлдвэрчний эвлэлийн гудамж хүртэлх хэсгийн цэвэрлэгээний ажлыг 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хооронд 66 рейсээр 1188,7 м<sup>3</sup> лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



Сонгинохайрхан дүүргийн 30,31,43 дугаар хороо Баруун уулын суваг 1 дүгээр хорооллын арын хэсгийн цэвэрлэгээний ажлыг 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн хооронд 74 рейсээр 1619,7 тн лаг хагшаасыг Морингийн даваа, нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо толгойтын суваг шинэ замаас үйлдвэрчний эвлэлийн гудамж хүртэлх хэсгийн цэвэрлэгээний ажлыг 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хооронд 66 рейсээр 1188,7 м<sup>3</sup> лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



СБД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Ногоон нуурын үерээс хамгаалах байгууламж, ЧД 9 дүгээр хороо Ногоон нуураас Баянбуурдийн гаргалгаа орох хэсгийн паг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хооронд 96 рейсээр 2519 тн лаг хагшаасыг Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.




БГД-ийн 9,10,11,12,22-р хорооны нутаг дэвсгэрт байрлах T1,T2,T3,TT1,TT2,TT3 тунгаагууруудын лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хооронд 113 рейсээр 2664 лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн ажилласан.



Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороо дэнжийн мянгын 3-р суваг, Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо Сэлбэ дэд төвийн сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд 29 рейсээр 501 м<sup>3</sup> лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн ажилласан.



СХД-ийн 5,6,23,27-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Намгийн сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд 133 рейсээр 2184 м<sup>3</sup> лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



СХД-ийн 2,20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Баруун наран, дунд наран, зүүн нарангийн сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хооронд 237 рейсээр 4072 м<sup>3</sup> лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



БГД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Баруун уулын суваг Толгойтын суваг нийлэх хэсгээс Эрчим хүчний гудамж хүртэлх хэсгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд 168 рейсээр 1873 м3 лаг хагшаасыг Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



СХД-ийн 19-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Толгойтын сувгаас баруун уулын суваг хүртэл хэсгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн хооронд 83 рейсээр 1209,3 м3 лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.




ЧД-ийн 18-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Сэлбэ дэд төвийн сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд 28 рейсээр 467,2 м3 лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



СХД-ийн 3,4-р хорооны нутаг дэвсгэрт байрлах үерээс хамгаалах сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 15 рейсээр 271,6 м3 лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



СХД-ийн 32-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 3,61 гарамын үерээс хамгаалах байгууламжийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд 42 рейсээр 875,4 м<sup>3</sup> лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



2024-11-01 16:15



2024-11-01 16:47

СХД-ийн 09-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Баянхшуу дэд төвийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 31 рейсээр 645,2 м<sup>3</sup> лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



Nov 6, 2024 09:36:24



Nov 7, 2024 14:19:10

ЧД-ийн 5-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Баруун уулын суваг(Гэсэр сүмийн зүүн суваг)-ийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд 28 рейсээр 532,3 м<sup>3</sup> лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.





Nov 8, 2024 13:25:14



Nov 8, 2024 12:52:25

БГД-ийн 12,20,21,22-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 3,4-р хорооллын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн лаг цэвэрлэгээний ажлыг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд 92 рейсээр 1739 м<sup>3</sup> лаг хагшаасыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэн ажилласан.



#### ГУРАВ. ҮЕРИЙН ХАМГААЛАЛТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН

**6 БАЙРШИЛД 727 М/УРТ ЗАСВАР НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН**

БЗД-ийн 10,35-р хороо Ээж хайрханы суваг Улиастай голтой нийлэх хэсгийн засвар нөхөн сэргээлтийн ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хооронд **80 м** сувгийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.




ХУД-ийн 3-р хороо Шунхлай ШТС буулгасан хэсгийн дунд голын эргийн хамгаалалтын далангийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хооронд **207 м** сувгийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



ЧД 13, 14-р хороо Хайлаастын үерийн хамгаалалтын сувгийн засвар нөхөн сэргээлтийн ажлыг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хооронд 150 м газарт хийж гүйцэтгэсэн.




БЗД 21, 27-р хороо Ганц худгийн үерийн хамгаалалтын сувгийн засвар нөхөн сэргээлтийн ажлыг 2024 оны 10-р сарын 23-ны өдрөөс 11-р сарын 08-ний өдрийн хооронд 150 м газарт төмөр бетон хавтан суурилуулан ажилласан.




БЗД 13,14-р хороо Зүүн уулын үерийн хамгаалалтын сувгийн засвар нөхөн сэргээлтийн ажлыг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд 40 м газарт босоо хана цутган ажилласан.



БГД 2-р хороо Баруун уулын үерийн хамгаалалтын сувгийн засвар нөхөн сэргээлтийн ажлыг 2024 оны 10-р сарын 10-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд 30 м газарт босоо түшиц хана цутган ажилласан.



ХУД-ийн 15-р хороо Энхтайвны гүүрний зүүн талын нүхэн гарцны замын гүүрний хэсэгт Дунд голын эргийн хамгаалалтын барилгын өргөтгэл, шинэчлэл, засварын ажлыг 2024 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хооронд 70 м газарт босоо түшиц хана цутган ажилласан.



### **ДӨРӨВ. ЖАРГАЛАНТЫН АМНЫ УГСРАЛТЫН АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭВ.**

Жаргалантын амны уулнаас их хэмжээний үер бууж, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв, Архивын ерөнхий газар, "Буянт-Ухаа 2" хороолол үерт автах эрсдэл үүсэж байсан. Тус үерийн хамгаалалтын даланг хоёр сувагтайгаар буюу хоёр байршилд угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд хоёрдугаар сувгийн 800 метр далан бүрэн дуусаж, ашиглалтад оруулсан.


Байгууламж 1-н барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд Үндэсний биелүүлийн сургуулийн дотуур байрны газар чөлөөлөлтөөс шалтгаалж ажил түр зогсоод байна.





### ТАВ. ДУНД, СЭЛБЭ ГОЛЫН ЛАГ ХАГШААС ЗӨӨЖ ТЭЭВЭРЛЭХ, МОД БУТ ШИЛЖҮҮЛЭХ АЖИЛ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоол Нийслэлийн Онцгой комиссын 2024 оны 01,02 дугаар тогтоол Нийслэлийн Онцгой комиссын 04,05,06 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хөрөнгө гаргах тухай A/811 дүгээр захирамжийн дагуу Гамшгийн "Шар түвшин"-ий үед Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрүүдийг хамарсан Сэлбэ, Дунд гол дагуух лаг хагшаасыг ухаж, мод бургасыг нүүлгэх, цэвэрлэх, тээвэрлэх ажлыг нийт 32 аж ахуй нэгж байгууллагууд 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс хийж гүйцэтгэн 149 349 м<sup>3</sup> лаг хагшаасыг төвлөрсөн хогийн цэгүүд рүү зөөж тээвэрлэх ажилд байнгын хяналт тавин ажилласан.



### "АВТО ЗАМЫН БОРООНЫ БОЛОН ХӨРСНИЙ УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМ СУЛЖЭЭ, МОНИТОРИНГИЙН ЦООНГОГИЙН АЖЛЫН ЖИЛИЙН ТАЙЛАН

#### Замын ус зайлцуулах шугам, худгийн засвар, өргөтгөлийн ажил:

#### Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажил:

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн A/784 тоот захирамжаар нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар Замын ус зайлцуулах шугам, худгийн засвар, өргөтгөлийн ажлын жагсаалт батлагдсан. Энэ ажлын хүрээнд 8 байршилд шинээр замын ус зайлцуулах шугамын ажил хийгдсэн, мөн ус зайлцуулах шугам, суваг, шүүрт болон үзлэгийн худагт засвар нөхөн сэргээлтийн ажил хийгдлээ.

1. Нийслэлийн 6-н дүүргийн хэмжээнд борооны болон хөрсний ус зайлцуулах шугам сүлжээний худгийн засвар нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд графикийн дагуу засвар нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

- 40x50 шүүрт худгийн таг нөхөн сэргээх-10ш
- 40x50 шүүрт худгийн засвар- 1ш

- 40x80 шүүрт худгийн таг нөхөн сэргээх -38ш
- 40x80 шүүрт худгийн засвар-124ш
- Үзлэгийн худгийн таг нөхөн сэргээх -24ш
- Үзлэгийн худгийн засвар-33ш
- Сувгийн таг нөхөж тавих-350м
- Хөндлөн шүүр 8м
- Улсын их дэлгүүрийн зүүн талын явган гарцын ус зайлцуулах хуванцар хоолойг тасалж гэмтээн улмаар лаг хагшаасаар дүүрч ус тогтох иргэд зорчиход хүндрэлтэй нөхцөл байдал үүсгээд байсан бол тасалж гэмтээсэн хуванцар хоолойг ган хоолойгоор сольж ажиллалаа.

Нийт 422ш таг нөхөж, 158ш шүүрт болон үзлэгийн худгийн тагийг засварласан.



Номин их дэлгүүрийн урд талын шугам, худгийн өргөтгөл (БГД, 14 дүгээр хороо) ф300 хуванцар футляр хоолой 22у/м, шүүрт худаг 4ш, асфальт 5тн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нийт шугамын урт 22у/м.





Хасбаатарын гудамж, Хүрээ дээд сургууль орчмын шугам, худгийн өргөтгөл (БГД, 12 дугаар хороо) ф300 хуванцар хоолой 84у/м, ф400 ган футляр хоолой 7у/м, шүүрт худаг 8ш, үзлэгийн худаг 1ш, авто замын хашлага 85м, явган зам авто замын асфальт 13тн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нийт шугамын урт 84у/м



Сүлжмэлийн үйлдвэрийн урд хаалга орчмын зам талбай (СХД, 29 дүгээр хороо) ф300 хуванцар хоолой 62у/м, ф400 ган футляр хоолой-12у/м, шүүрт худаг 9ш, үзлэгийн худаг 1 ш, авто замын хашлага 32 м, явган зам авто замын асфальт 6 тн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нийт шугамын урт 68у/м.





Таван буудал орчмын авто замд шүүрт худаг нэмэх (СБД, 13 дугаар хороо) ф400 хуванцар хоолой 88у/м, ф500 ган футляр хоолой бу/м, шүүрт худаг 13ш, авто замын хашлага 76м, явган зам авто замын асфальт 10тн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нийт шугамын урт 88у/м



Наран хотхон, Петровисын ШТС орчмын авто замын борооны ус зайлцуулах шугамын ажил. Энхтайваны гүүрэн доорх гаргалгаа шугамын өргөтгөл (ХУД, 1 дүгээр хороо) ф275 ган хоолой 64у/м, ф600 хуванцар хоолой 48у/м, ф800 ган футляр хоолой 21 у/м, шүүрт худаг 10ш, явган замын хавтан 153.5м<sup>2</sup> нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нийт шугамын урт 112у/м



16 дугаар сургуулийн хажуугийн авто замын борооны ус зайлцуулах шугамын шинэчлэлт (СБД, 11 дүгээр хороо) ф300 хуванцар хоолой 120у/м, ф400 хуванцар хоолой 291у/м, ф500 ган футляр хоолой 35у/м, шүүрт худаг 25ш, үзлэгийн худаг 12ш, явган замын хавтан 257м<sup>2</sup>, авто замын хашлага 200у/м, асфальт 30тн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нийт шугамын урт 411у/м



Эрэлийн байрны урд талын туслах авто замын борооны ус залуулах худгуудын шинэчлэлт (ХУД, 1 дүгээр хороо) ф300 хуванцар хоолой 22у/м, шүүрт худаг 2ш, үзлэгийн худаг 2ш явган замын хавтан 33м<sup>2</sup>, авто замын хашлага 22у/м, авто замын асфальт 4.5тн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нийт шугамын урт 22у/м



Механик, тээврийн сургуулийн арын уулзварын зүүн талын ус тогтдог хэсгийн авто замын шугамын ажил (Хараагүйчүүдийн байрны урд зам ХУД, 3 дугаар хороо) ф300 хуванцар хоолой 169у/м, ф400 ган футляр хоолой 24у/м, шүүрт худаг 9ш, авто замын хашлага 156у/м, явган зам авто замын асфальт 24тн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нийт шугамын урт 169у/м.





Улаанбаатар хотын Захирагийн ажлын албаны хөрөнгөөр хэрэгжүүлэх ажил:

Улаанбаатар хотын ерөнхий менежерийн Санхүүжилт шийдвэрлэх тухай А/62 дугаар тушаал болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 4 байршилд шугамын өргөтгөл шинэчлэлт болон засварын ажил хийгдлээ.


Баянзүрх дүүрэг 2 дугаар хороо, Дарь эхийн замын ус зайлцуулах шугам сүлжээний засвар, өргөтгөл шинэчлэлтийн ажлын талбайд шүүрт худаг 25ш, үзлэгийн худаг 13ш, Y3.X6.1-ШХ6.1,Y3.X6.2 ШХ6.2хүртэл ф300 хуванцар хоолой 226м, ф500 төмөр бетон хоолой 72м, ф500 хуванцар хоолой 235м угсарч, ф400 хуванцар хоолой 69м холбож илүүдэл широог ЦДТХ цэгт буулган ажиллалаа.



Хан-Уул дүүрэг 15 дугаар хороо, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадны зам талбайн ус тогтдог байршлын замын ус зайлцуулах шугам сүлжээний засвар, өргөтгөл шинэчлэлтийн ажил Ус хуримтлуулах худаг 4ш угсралт, 200ф ган хоолой 46м, лотки 15м, ф400 ган хоолой 82м, ф600 ган хоолой 14м, 400ф хуванцар хоолой 219м, 500ф ган бутлер хоолойн 30м, ф300 хуванцар хоолой 602м угсралтын ажил хийгдэв.



Чингэлтэй дүүрэг 24 дүгээр хороо, Япон цэргийн цогцолборын авто зам, Санзайн авто замтай нийлэх хэсэг, Сэлбэ голын баруун талд ус тогтдог байршлын замын борооны ус зайлцуулах шугам сүлжээний засвар, өргөтгөл шинэчлэлтийн ажил: Нийт 85у/м ф300-н хуванцар хоолой, 94у/м ф400-н хуванцар хоолой, 24у/м ф500-н ган футлер хоолой, 12ш шүүрт худаг, 2ш үзлэгийн худаг угсарч, 87ш авто замын хашлага, 87ш явган замын хашлага хийж ажилласан.



Чингэлтэй дүүрэг 24 дүгээр хороо, Санзайн зам дагуух ус тогтдог байршлын замын борооны ус зайлцуулах шугам сүлжээний засвар, өргөтгөл шинэчлэлийн ажил






СХД 18-р хороо 2, 24 дүгээр байрны борооны ус зайлцуулах шугам угсралтын шугам, худгийн өргөтгөлийн ажилд нийт 320м шугам, шүүрт худаг 16ш, үзлэгийн худаг 7ш хийж ажилласан. / Он дамжин хэрэгжих ажил/



### Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөр

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1009 тоот захирамжаар батлагдсан ажлын хүрээнд дараах 2 байршилд шугам угсралтын ажил хийж гүйцэтгэлээ.

Баянзүрх дүүргийн 24-р хороо Шар хадны авто зам Эрдэнэ толгойн борооны ус зайлцуулах шугамын угсралтын ажилд нийт 190м шугам, шүүрт худаг 17ш угсарч ажиллалаа.



Сүхбаатар дүүргийн 16-р хороо, 16-р сургуулийн зүүн талын борооны ус зайлцуулах шугамын угсралтын ажилд нийт 197м шугам, шүүрт худаг 20ш хийж ажиллалаа.



### Авто замын борооны болон хөрсний ус зайлцуулах шугам сүлжээний цэвэрлэгээ:

Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд авто замын борооны ус зайлцуулах шугамын цэвэрлэгээ үйлчилгээг 3 удаагийн давтамжтай хийж нийт 3063.5м<sup>3</sup> лагийг төвлөрсөн хогийн цэгт буулгаж ажиллалаа.



Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд авто зам дээр тогтсон усыг соруулах болон шугам хоолойг даралттай усаар угааж буудуулах ажлын хүрээнд: 111 байршилд авто зам дээр тогтсон 63049м<sup>3</sup> усыг соруулсан.




СХД-ийн 32 дугаар хороо, Тахилтын нүхэн гарцад авто замын ус зайлцуулах 434у/м урт шугам хоолой, шүүрт худаг 11ш, үзлэгийн 11ш, насост худаг 1ш хийж гүйцэтгэсэн байна.



### Мониторингийн цооногийн ажил:


2024 онд БЗД, СБД, ЧД, БГД, СХД-т байрлах Хөрсний усны мониторингийн 38ш цооногоос гараар болон автомат хэмжигчээр мэдээлэл авч ажиллалаа.



### Төв болон Хойд, Баруун, Зүүн хэсгийн хөрснийус зайлцуулах шугам худгийн засвар болон цэвэрлэгээний ажил:

1. БЗД 22-р хороо, Зүүн хэсгийн шугамд ф300 хуванцар хоолой 13у/м, кс10 h900 колъцо 1ш, пп10 хучилт 1ш, 40\*80 ком шүүр 1ш суулгалт угсралтын ажил хийгдсэн.
2. СХД 40-р хороо хилчин хотхоны арын шугам бөглөрсөнг худаг хооронд өглөрсөнг 200у/м газар буудан, 150у/м газар хоолой шалган, ф300 хуванцар хоолой 30у/м шинээр угсарч, 7 рейс 140 тонн дайрга дүүргэлт булалт хийн ажиллалаа.





3. Үзлэгийн худагт ширмэн люк таг 15ш, дт1 бетонон таг 15ш, кс10, h=600 кольцо 5ш, пп10 хучилтын хавтан 10ш, кс10 h=900 кольцо 2ш шинээр нөхөн сэргээж ажиллалаа.


БЗД 24-р хороо Эрдэнэ толгой Дако төвийн урд зам үзлэгийн худгийн засвар-1ш



БЗД-ийн 38-р хороо, Зүүн хэсгийн хөрсний усны шугамын үзлэгийн худагт, ДТ бетон таг 1ш, ширмэн ком таг 1ш,



4. БЗД 26 хороо, Баянмонгол хороолол, Хойд болон Төвийн хэсгийн хөрсний усны шугам далд хэсэг цемөрч шороо хайрга дүүрсэнг гараар гаргаж цэвэрлэв.



#### **Нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилттэй холбогдолтой мэдээлэл:**

Нийслэлийн удирдах ажилтнуудын 7, 14 хоногийн шуурхай зөвлөгөөнөөр өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг Хяналт шинжилгээ үнэлгээ (өгр программын хяналт, шинжилгээ үнэлгээ) цахим системд 19 удаагийн Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгдсөн 61 үүрэг даалгаврын биелэлтийг байршуулж, мэдээ тайланг бэлтгэн цаг хугацаанд нь тайлагнасан.

Цаг үеийн шинж чанартай бусад тайлан мэдээ болон Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлсэн тайлан мэдээг цаг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлсэн.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 18 удаагийн шуурхайн 31 үүрэг даалгаварын биелэлт болон үйл ажиллагааны 14 хоногийн 24 удаагийн биелэлтийн тайланг нэгтгэн [zaa.audit@gmail.com](mailto:zaa.audit@gmail.com) цахим хаягаар мөн албан бичгээр хүргүүлсэн.

Мөн цаг үеийн шинж чанартай тайлан мэдээ болон хот нийтийн аж ахуйн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг заагдсан хугацаанд гаргаж биелэлтийг хангаж ажилласан.

**Иргэээс ирүүлсэн өргөдөл, гомдолын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл;**

2024 онд иргэд болон албан хаагчдаас нийт 303 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд Удирдлага-3, Захиргаа, хүний нөөцийн хэлтэст 107, Өндөржилт төлөвлөлтийн хэлтэст 48, Санхүүгийн алба-4, Шуурхай удирдлагын алба-1, Засвар ашиглалтын албанад 94, Хяналт аюулгүй ажиллагааны албанад 46 өргөдөл, гомдол тус тус ирснийг хүлээн авч бүртгэн, ERP програмд 1-3 шат дамжлагатайгаар шилжүүлсэн.

Нийт 300 өргөдлийг эцэслэн шийдвэрлэсэн. Өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 хоног 17 цаг 07 минут бөгөөд өргөдөл гомдолын дундаж индекс 98%-тай байна.

**Шуурхай дуудлагаын мөрөөр үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, авто замын зорчих хэсгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг түргэн шуурхай зохион байгуулж ажиллах хүрээнд:**

1. Нийслэлийн хэмжээнд хур бороо ихээр орж үер усны аюулд өртөх нөхцөл байдал үүсэх, хөрсний ус, булгийн ундаргын түвшин дээшилж айл өрх аж ахуй нэгжийг усанд автас эрсдэлээс сэргийлэх, мөн авто замын болон явган хүний зорчих хэсгийн зам талбайг усанд автуулахгүй хэвийн ажиллагааг хангах үүднээс тус газрын Шуурхай удирдлагын төвийн 77200200, 89280280, 95280280 дугаарын утсанд шуурхай дуудлага ирсэн даруйд холбогдох албан тушаалтанд мэдэгдэн шуурхай зохион байгуулалт хийн арга хэмжээ авч, гарч болох эрсдэлийг бууруулан ажиллаж байна.

2024 онд "Шуурхай удирдлагын алба"-д 6 дүүргийн хэмжээнд нийт 649 дуудлага ирснээс Шугам сүлжээ-261, Далан суват-55, Ус сорох-101, Ус шавхалт-45, Харьяаллын бус-131,Халиа дошин 56 дуудлага ирсэн байна.

Халиа тошингийн дуудлага болон Шар усны үерийн усны байгууламжийн 6 сувагт 56 дуудлага ирсэн байна. Чингэлтэйн суваг, Дэнжийн 1000-н 1- суваг, Дэнжийн 1000-н 3 суваг, Толгойтын суваг, Сэлбэ гол, Зүүн уулын сувагт дуудлага ирж аж ахуй нэгж ард иргэдийн аюулгүй байдлыг ханган ажиллаа.

3. "Шуурхай дуудлагаар ажиллах бригад"-д ажиллах хуваарийн дагуу инженер, техникийн ажилчид өдөр тутмын хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээг фото зураг, тайлбарын хамт байгууллагын цахим группт байршуулж хэвшсэн. УБХШУЗТ, НОБГ цаг үеийн болон өдөр тутмын мэдээллээр ханган ажиллаж байна.

**Байгууллагын албан бичгийн боловсруулалт шийдвэрлэлт, архивын нэгдсэн арга хэмжээг хэрээжүүлэх ажлын хүрээнд:**

1. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ERP, EDOC системийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах ажлын хүрээнд байгууллагад хэрэглэгддэг албан хэрэг хөтлөлтийн программ ашиглалтын аюулгүй ажиллагааг хангаж, өдөр тутам албан хэргийг хөтлөн явуулж байна.

2. Албан бичгийг Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол дахь стандартын дагуу боловсруулж байна. Ирсэн албан бичгийг газрын даргад танилцуулж, холбогдох албан хаагчдад шуурхай шилжүүлэн ажиллаж, шийдвэрлэсэн бичгийг цаг тухай бурд нь хяналт тавьж байна. EDOC програмд жилийн байдлаар 973 ирсэн бичгийг бүртгэж холбогдох алба хаагчдад шилжүүлж шийдвэрлэсэн. Албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7-14 хоног байна.

3. Байгууллагаас гарч буй явсан албан бичгийг стандартын дагуу боловсруулан хянаж, тоон гарын үсгээр баталгаажуулан тухайн байгууллага руу илгээж, тоон гарын үсэгний

хэрэглээний ашиглалтыг 100%-д хүргэсэн. Байгууллагаас нийт 618 албан бичиг тоон гарын үсгээр баталгаажуулан илгээгдсэн байна.

4. 2023 онд Даргын А тушаал 46, Б тушаал 173 гарсан. Үүнийг архивын Archive EDoc системд баримтыг стандартын дагуу бүртгэн, хянуулж Нийслэлийн Архивын газарт хувийг хургуулж ажилласан.

5. 2024 онд Газрын даргын тушаал А тушаал-53, Б тушаал-203 боловсруулагдан гарсан байна.

**Борооны болон хөрсний ус зайлцуулах өргөлтийн насос станцын ашиглалт, засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх ажлын хүрээнд.**

Өргөлтийн насос станцад 2, 4-р насосоор өдөрт 600м<sup>3</sup> ус соруулан бороо орох үед насос станцыг 6-48 цагаар ажиллуулж хөрсний ус зайлцуулах системийг суллах ажил хийж нийт 447,600м<sup>3</sup> усыг далан руу зайлцуулсан.

Гадна 64м<sup>3</sup>-н усан санд 31тн лаг цэвэрлэгээг хийж гүйцэтгэсэн. Дотор 170м<sup>3</sup> ус хүлээн авах санд 12тн лаг цэвэрлэгээний ажил хийгдэж ф100 үл буцах хаалтыг сольж байрлуулсан.

- 5-н дүүргийн 11 байршилд зөөврийн насос худгуудад давтамжтай цэвэрлэгээ, үйлчилгээ хийгдэж нийт 103,7м<sup>3</sup> лагийг хогийн цэгт буулгасан.
- ХУД 15-р хороо Төв цэнгэлдэх хүрээлэнд 11квт, 15квт-ийн автозамын борооны ус зайлцуулах насос худаг суурилуулж ажилласан.
- СБД 1-р хороо Замын цагдаагийн газар, Гадаад харилцааны яамны хажууд 11квт, 22квт-ын 2 насос суурилуулсан.

СХД 32-р хороо Тахилтын нүхэн гарцын насос худгийн шугамын угсралт холболтыг хийж 22квт, 35квт-ын насосуудыг суурилуулан ажилласан.

6-н дүүргийн 12 насос худгийг суурьлуулан засвар үйлчилгээ, цэвэрлэгээг тогтмол гүйцэтгэж, цахилгааны шийт хариуцан ажилласан.

Хан-Уул дүүрэг 15 дугаар хороо, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн борооны ус зайлцуулах шугам угсралтын ажил хийгдэж, насос худгийн шахах шугамын угсралтын ажлыг хийж гүйцэтгэн, тоног төхөөрөмж, холболтын эд анги суурилуулах ажил хийгдэж гүйцэтгэсэн.



### Төсөө санхүүгийн ил тод байдлын хэрэгжилт:

[www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад 2024 оны 01-р сараас 12-р сар хүртэл шилэн дансны мэдээллийн санд худалдан авах ажиллагааны хөрөнгө урсгалын зардал болон ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлгийг тухай бүрд нь оруулж ажилласан. Байгууллагын шилэн дансанд мэдээ мэдээллийн цаг тухай бүрд нь оруулан ажиллаж байна.



Нийт 6 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг териин худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр давхардсан тоогоор 7 удаа зохион байгуулж ажилласан. Зарласан тендерээс амжилттай зохион байгуулсан 5, тендер шалгаруулалт хүлээн авч байгаа 1 төсөл арга хэмжээ байна. Зохион байгуулалтын тайлан мэдээ, үр дүнг тухай бүр нь байршуулж оны эцсийн тайлан мэдээг худалдан авах ажиллагааны цахим системээр илгээсэн.

[www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад 2024 оны 01 дүгээр сараас 12 дугаар сар хүртэл шилэн дансны мэдээллийн санд худалдан авах ажиллагааны хөрөнгө урсгалын зардал болон ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлгийг тухай бүрт нь оруулж ажилласан. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө хэсэгт нийт 3 төсөл хөтөлбөрийн мэдээлэл оруулж, ашиг сонирхлын зөрчилгүй тухай 6 төсөл арга хэмжээний 30 мэдүүлэг бөглүүлж мэдээллийг ил тод байршуулсан.

Мөн ХХОАТ-ын тайлан, НДШ-ийн тайланг цаг хугацаанд нь холбогдох байгууллагад тухай бүр тайлагнаж ажилласан.

### Байгууллагын үйл ажиллагаанд иргэд олон нийтийг татан оролцуулсан тухай мэдээлэл:

2024 онд нийт 66 удаагийн цаг үеийн шинжтэй үйл ажиллагааны талаар шинэ мэдээ, мэдээллүүдийг тухай бүр байгууллагын албан ёсны пэйж хуудсанд байршуулсан.



Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хийгдсэн бутээн байгуулалтын ажлын мэдээллийг фото зургийн хамт цаг тухай бүрт нь цахим хуудсанд байршуулсан.



Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой иргэд олон нийтэд чиглэсэн, зөрчил арилгах, үйлчилгээ үзүүлэх, цаг үеийн нөхцөл байдлын талаар олон нийтийн телевиз / NTV, MNB, TB6, TB9, ETV, / Улаанбаатар мэдээ зэрэгээр дамжуулан ярилцлага өгч, мэдээ мэдээллийг хүргэсэн.

### Ярилцлага, нэвтрүүлэг хэвлэл мэдээлэл оролцсон байдал:

Олон нийтийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ГУББГ-ын Ерөнхий инженер С.Батсайхан, байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой зөрчил арилгах, үйлчилгээ үзүүлэх байгууллагын үйл ажиллагааны талаар иргэд олон нийтэд нийт 17 ярилцлага мэдээлэл өгсөн.



Жил бүрийн хаврын улиралд шар усны үер, булаг шандны усны халия тошин урсаж, нийслэлийн зарим дүүргийн гэр хорооллын айл өрхүүд хүнд нөхцөлд аж төрдөг. Энэ талаар бусад авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар Геодези, усны барилга, байгууламжийн газрын дарга Л. Ариунтуяа нийт 8 ярилцлага мэдээ мэдээллийг олон нийтэд өгсөн.



Манай байгууллагаас нийт нийслэлийн ард иргэддээ хандан үерийн хамгаалалтын далан сувагт ахуйн хог хаягдлыг хаяхгүй, эвдэж гэмтээхгүй байх талаар уриалга бэлтгэн гаргаж олон нийтэд тогтмол түгээж байна.



### ШУТИС-ын оюутнуудыг хүлээн авч байгууллагын үйл ажиллагааг сурталчилан таниулах ажлыг зохион байгууллаа.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчилан таниулах зорилгоор ШУТИС-ийн Барилга, Архитектурын сургуулийн Инженерийн байгууламжийн салбар, Усны барилга байгууламжийн ангийн оюутнуудыг хүлээн авч Геодези, Усны барилга байгууламжийн газрын хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааг танилцуулах, ирээдүй хойч үеээ чадвартай, оюунлаг инженер болоход нь мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгч "Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний өнөөгийн байдал"-сэдвээр сургалт, дадлагын ажлыг зохион байгууллаа.

Мөн Өргөлтийн насос станцаар орж 64м<sup>3</sup> ус хүлээн авах гадна усан сан, үл буцах хаалт, хог шүүх сараалж, 600 м<sup>3</sup>/цаг-5000 м<sup>3</sup>/цаг ус соруулах хүчин чадалтай насосуудын ажиллах зарчим, ач холбогдол цахилгаан хангамжийн болон бусад техник тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааг танилцууллаа.





**“Тэрбум мод”**

“Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтийн мод тарих өдөр буюу өнөөдөр (2024.05.13) “Геодези, Усны барилга байгууламжийн газар”-ын албан хаагчид Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороонд байрлах “Хайрхан Хөгжлийн төв 1”-ийн орчим Эрдмийн цэцэрлэгт хүрээлэнд агч мод, бургас, улиас, хайлаас зэрэг олон төрлийн 100 гаруй мод, сөөгийг тарилаа.



**2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг шалгах дадлага зохион байгуулагдлаа.**

Монгол Улсын гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Гамшгаас хамгаалах хууль болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангуулах, төрийн байгууллагуудын гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг сайжруулах чиглэлээр Улаанбаатар хотын гэрэлтүүлэг ашиглалт, инженерийн хангамжийн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл, бэлэн байдлыг шалгаж, мэргэжлийн ангиудын үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлж нийслэлийн иргэдийг болзошгүй аваар, saatlaas урьдчилан сэргийлэх зорилго бүхий 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг шалгах дадлага зохион байгуулагдлаа.



**Гамшгийн эрсдэлийг бууруулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийг хүлээлгэн өглөө**

Гамшгийн эрсдэлийг бууруулах Нийслэлийн зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд ашиглах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж гардуулан өгөх арга хэмжээ өнөөдөр боллоо. Энэ үеэр НИТХ-ын төлөөлөгч Ж.Батбаясгалан Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Геодези, Усны барилга байгууламжийн газар, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК зэрэг байгууллагуудад гамшгийн эрсдэлийг бууруулахад нэн шаардлагатай эрэн хайх, аврах ажиллагааны багаж хэрэгсэл, химиин хувцас хэрэглэл, газар хөдлөлтийн тоног төхөөрөмж, паспортжуулалд,

Үерийн үед ашиглах тоног төхөөрөмжийг тус тус хүлээлгэн өгсөн. Нийслэлийн хэмжээнд тохиолддог томоохон аюулт үзэгдэл, ослын үед ашиглах нийт нэг тэрбум төгрөгийн өртөг бүхий багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гардуулан өгснөөр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, мэргэжлийн байгууллагуудын гамшигтай тэмцэх, чадавхыг дээшлүүллээ. Мөн Гамшигийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлт, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар танилцууллаа.



### Халиа тошин

Өнгөрсөн жилүүдэд их хэмжээний бороо орсны улмаас энэ жил эрт халиа тошин үүсэж хөрсний ус маш ихээр гарч байнгын урсацтай булаг, хөрсний уснаас халиа тошин үүсч далан сувгууд дүүрэх, ойр орчмын айл өрхүүдийн гэр, хашаа байшин усанд автан хөлдөх, зам талбайд хальтаргаа гулгаа үүсгэх эрсдэлтэй талаар ГУББГ-ын дарга Б.Бямбасайхан олон нийтэд З удаагийн ярилцлага мэдээ мэдээллийг хүргэж ажилласан.

Байгууллагын цахим хуудсаар анхааруулга, сээрэмжлүүлэг, ажлын үйл явцын мэдээ зэрэг нийт 11 удаагийн мэдээ мэдээллийг хүргэж ажилласан.



Геодезик, Усны барилга байгууламжийн газар ОНФААТУУТ  
December 25, 2024 at 10:25 AM

Халиа тошин үүсэгээ байршилдүүдэд тогтмол узлаг шалгалт хийн халиа үүссэн байршилдүүдэд шүүрхийн арга хэмжээ авч ажиллаж байна.

-Өнгөрсөн жилүүдэд их хэмжээний бороо орсны улмаас энэ жил эрт халиа тошин үүсэж хөрсний ус маш ихээр гарч байнгын урсацтай булаг, хөрсний уснаас халиа тошин үүсч далан сувгууд дүүрэх, ойр орчмын айл өрхүүдийн гэр, хашаа байшин усанд автан хөлдөх, зам талбайд хальтаргаа гулгаа үүсгэх эрсдэлтэй байна. Энэ нөхцөл байдлаас сэргийлэн ГУББГ-ын зүйлээ. Халиа тошин үүсэгээ байршилдүүдэд тогтмол узлаг шалгалт хийн халиа үүссэн байршилдүүдэд шүүрхийн арга хэмжээ авч бөгөөрөвсөн гур, хоолой гаргаж, суваг татан ус чөлөөтэй урсах нөхцөлийг бурдуулэн ажиллаж байна.

Х - Иргэд та бүхийтэй байгалийн хүрэй жалгаа сайж булаг шанд, гол горхи, үерийн хамгаалалтын далан сувагт оршиж сүүхийг байжиг хүснэ. Жалгаа сайж булаг шанд, гол горхи, үерийн хамгаалалтын далан сувагт оршиж сүүснээр ЗҮН НЬ ҮЕРТ, ӨВӨЛ НЬ ХАЛИА ТОШИН УС МИСЕНД, ХАВАР НЬ ШАР УСНЫ ҮЕРТ ӨРТӨХӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ БОЛОХЫГ АНХААРУУЛЖ БАЙНА.



Boost this post to reach up to 4138 more people if you spend \$14.

Boost post

You, Enkhtailkhan, Ариунтуяа Лхасасүрэн and 67 others

5 comments · 15 shares

Like

Comment

Copy

Share

ТАНИЛЦСАН:  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



2025 оны 01 сарын 03 өдөр

/Б.БЯМБАСАЙХАН/

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА:

*З. Монголцагч*

/Б.МОНХЦАЦРАГ/

2025 оны 01 сарын 03 өдөр

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ДОТООД АЖИЛ, ТАЙЛАН МЭДЭЭ  
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*С. Занис*

/Б.БОЛОРЦЭЦЭГ/